

“ШУДАРГА ЁСНЫ ТӨЛӨӨ” ШАГНАЛЫН ЗАГВАР



“Шударга ёсны төлөө” шагналын тодорхойлолт

“Шударга ёсны төлөө” шагнал нь өөрийгөө илчлэхийн бэлэг тэмдэг¹-Дигваранзын² арга, билгээр байрласан хос дүрсийг мөнгөөр товойлгон хийж, алтаар шарж, ногоон гантиг чулуун дээр 6 см голчтой зайд байрлуулж, түүний дээд хэсэгт “Шударга ёсны төлөө”, доод хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөл” гэсэн үгсийг мөнгөөр бичиж, алтаар шарж, чулуунд суулгасан байна.

Үндсэн хийцийн дээр трапец хэлбэрийн орой хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн бэлэг тэмдэгийг мөнгөөр хийж, алтаар шарж, чулуунд суулгана.

Шагналын дээд хэсэгт хүзүүнээс зүүх сүлжмэл мөнгөн оосортой байна. Оосорын урт нь 66 см байна.

Үндсэн хийцийн ард он, дугаарыг бичсэн мөнгөн ялтасыг чулуунд суулгана.


“Шударга ёсны төлөө” шагналын бэлгэдлийн зүүлтийг загварт заасан хэмжээгээр гар аргаар тухай бүрт нь хийнэ.

¹ Scorpion-Symbols of self-discovery гэсэн хэллэг дэлхий дахинаа түгээмэл хэрэглэдэг

² Говийн ноён хутагт Данзанравжаа “Дигваранз бээр бусдыг хорлож бус, өөрийг хорлож байгаа нь шударгын шинж юм, нүгэл хилэнц үйлдсэн хэн ч бол өөрийгөө дигваранз мэт шийтгэж чаддаг байваас шударгуу явдалтан болой” хэмээн үзэж, нууц тарнийн бүтээлийн тамгандаа дүрсийг нь ашиглаж байжээ.

“ШУДАРГА ЁСНЫ ТӨЛӨӨ” ШАГНАЛЫН ӨРГӨМЖЛӨЛИЙН ЗАГВАР


1. Өргөмжлөлийн хавтас /нүүр хэсэг/



2. Өргөмжлөлийн дотор тал



“ШУДАРГА ЁСНЫ ЭЛЧ” ТЭМДГИЙН ЗАГВАР



“Шударга ёсны элч” тэмдгийн тодорхойлолт

“Шударга ёсны элч” тэмдэг /цаашид “Тэмдэг” гэх/ нь эрч хүч, эвдэршгүй бат бэхийн бэлгэдэл болох Нацагдорж дүрс дээр шүүх хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа болохыг илэрхийлсэн Монгол Улсын Шүүхийн бэлгэ тэмдгийг байрлуулсан байна.

Шүүхийн бэлгэ тэмдгийг тойруулан “ШУДАРГА ЁСНЫ ЭЛЧ” /дээд хэсэгт “шударга ёсны” доод хэсэгт “элч” гэж/ гэсэн үгийг мөнгөлөг өнгөөр цэнхэр өнгийн дэвсгэр дээр бичнэ.

Нацагдорж дүрс нь бараан саарал өнгөөс уусч цайрсан мөнгөлөг өнгөтэй товгор байх ба дэлбээний уг тус бүрт муу зүйлээс хамгаалах ариун сахиусны бэлгэдэл шүр эрдэнийг байрлуулсан байна.

“Шударга ёсны элч” тэмдэгт илэрхийлсэн дүрсүүдийн хэмжээг загварт заасны дагуу хийнэ.

Тэмдгийн ар талд хувцсанд тогтоох зүү байна.

“ШУДАРГА ЁСНЫ ЭЛЧ” ТЭМДГИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

1. Үнэмлэхний хавтас



2. Үнэмлэхний дотор тал

“ШУДАРГА ЁСНЫ ЭЛЧ” ТЭМДГИЙН	Хүндэт н. _____ Танаа
ҮНЭМЛЭХ	Шүүх эрх мэдлийг үр нөлөөтэй, бүтээмжтэй, хариуцлагатай хэрэгжүүлж, шүүхийн шинэчлэлд бодитой хувь нэмрийг тань үнэлж, ”ШУДАРГА ЁСНЫ ЭЛЧ” тэмдгээр шагнаж, энэхүү үнэмлэхийг олгов.
Дугаар: . . .	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА _____/_____/_____/
	20... он ... сар ... өдөр

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ИЙН ЗАГВАР



Монгол Улсын дээд шүүхийн “Хүндэт тэмдэг”-ийн тодорхойлолт

Монгол Улсын дээд шүүхийн Хүндэт тэмдгийн оройн хэсэгт төрийн соёмбыг байрлуулсан байх ба гол хэсгийг товойлгон Монгол Улсын шүүхийн бэлгэ тэмдэг болох дугуй хэлбэрийн дэвсгэр дээр үнэн цагааны билэгдэл хүндэтгэлийн навчин хүрээтэй, аливаа хууль бусыг даран арилгахыг билэгдсэн суман голчтой, хэрэг маргааныг нягтлан дэнсэлж гагцхүү үнэнийг тогтоох дэнсний хэлбэртэй байх бөгөөд бат бөхийн бэлэгдэл хар өнгөөр дүрслэгдсэн байна.

Голын бэлэгдлийг тойруулан “Монгол Улсын дээд шүүхийн Хүндэт тэмдэг” гэсэн үгийг алтан шаргалаар цэнхэр өнгийн дэвсгэр дээр бичнэ.


Тэмдэг 10 ширхэг талстат 5 цацрагаас бүрдсэн нь шүүхийн үйл ажиллагаа дөрвөн зүг, найман зовхист мандан цацрахыг, цацрагуудын хоорондох 5 ширхэг бад нь хууль ёс улс орон даяар түгэн дэлгэрэхийг, тус бадан дээрх шигтгээ нь үнэн шударгыг тус тус илэрхийлнэ.

Тэмдгийн дугаригийн голч 40 мм, түүний доторх шүүхийн бэлгэ тэмдгийн голч 18 мм байна.

Тэмдгийн ард талд тэмдгийг хувцсанд тогтоох зүү байна.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР


1. Үнэмлэхний хавтас



2. Үнэмлэхний дотор тал



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ИЙН ЗАГВАР



Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Хүндэт тэмдэг”-ийн тодорхойлолт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Хүндэт тэмдэг” нь хэзээд төгсгөлгүй сайны бэлгэдэл болох Өлзий хээн дээр шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хамгаалах захиргааны чиг үүргийг илэрхийлсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн бэлгэ, тэмдгийг байрлуулсан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн бэлгэ, тэмдгийг тойруулан “ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ, ХҮНДЭТ ТЭМДЭГ” /дээд хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөл” доод хэсэгт “Хүндэт тэмдэг” гэж/ гэсэн үгийг хар хөх өнгөөр мөнгөлөг өнгийн дэвсгэр дээр бичнэ.

Өлзий хээ нь талст бүхий алтан шаргал өнгөтэй товгор байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Хүндэт тэмдэг”-т илэрхийлсэн дүрсүүдийн хэмжээг загварт заасны дагуу хийнэ.

Тэмдгийн ар талд хувцсанд тогтоох зүү байна.

**ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
“ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР**

1. Үнэмлэхний хавтас




2. Үнэмлэхний дотор тал

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ИЙН	Хүндэт н. _____ Танаа
ҮНЭМЛЭХ	Шүүхийн эрх мэдлийн байгууллагын хөгжил, шинэчлэлд оруулсан хувь нэмрийг тань үнэлж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ээр шагнаж, энэхүү үнэмлэхийг олгов.
Дугаар: . . .	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА _____ / _____ /
	20... он ... сар ... өдөр

ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ

1. Эцэг/эх-ийн нэр: 2. Нэр:.....
3. Төрсөн огноо:..... 4. Хүйс:.....
5. Төрсөн аймаг, сум:.....
6. Одоогийн харъяалал:.....
7. Нийгмийн байдал:.....
8. Регистр:.....
9. Боловсрол:..... 10. Ажилладаг салбар:
11. Мэргэжил:.....
12. Улсад ажилласан жил 13. Шүүхэд ажилласан жил
14. Шүүгчээр ажилласан жил
15. Урьд болон одоо ажиллаж байгаа газар



Д/д	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1.			
2.			
3.			

14. Урьд шагнагдаж байсан шагналууд:

Д/д	Шагналын нэр	Шагнагдсан огноо
1		
2		

15. Шагнуулах үндэслэл:
16. Шагнуулах тухай хамт олны санал:
17. Хамт олны саналын хувь: